

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны
03 дугаар сарын 15-ны өдрийн А-43
дугаар тушаалын хавсралт

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ ИННОВАЦИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд “...салбарын хөгжлийн зорилтыг хангахын тулд өндөр бүтээмжтэй, дэвшилтэт технологийг салбар бүрт нэвтрүүлэх, инноваци шингэсэн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин урамшуулах зарчим баримтлана” гэж;

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан **Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогод** “хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй, мэдлэгт суурилсан тогтвортой хөгжлийн чиг баримжаатай хөгжүүлэх, инновацийг нэвтрүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх” гэж;

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 306 дугаар тогтоолд “...салбарын инновацийн тогтолцоо нь Үндэсний инновацийн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болно” гэж;

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 198.5-д “салбарын инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулах” гэж тус тус заасан.

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 18.0 хувийг бүрдүүлж, нийт ажиллах хүчний 38.5 хувь нь ажиллаж буй хүнс, хөдөө аж ахуйн салбарт инновацийн эко системийг бүрдүүлэх замаар мэдлэгийн, ногоон эдийн засгийг хөгжүүлэх явдал чухал байна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь өнөөгийн байдлаар биологийн нөөцөд түшиглэсэн, бүтээмж, үр ашиг багатай, хүрээлэн буй орчин, нөөцөд ээлгүй, нам технологитой, байгалийн эрсдлээс шууд хамааралтай хэвээр байна. Хэдийгээр өнгөрсөн хугацаанд салбарын тулхтай хөгжлийг хангахад чиглэгдсэн туршилт, судалгааны ажлууд нилээд хийгдсэн ч шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн хамтын ажиллагааны оновчтой менежмент бүрэлдээгүйн улмаас судалгааны ажлын үр дүн үйлдвэрлэлд бүрэн нэвтэрч үр ашгаа өгөхгүй байна. Мөн судлаачид оюуны бүтээлээ зах зээлийн эргэлтэнд оруулах сэтгэлгээ төлөвшөөгүй, үйлдвэрлэл эрхлэгчид нь шинэ технологи, бүтээгдэхүүний үр дүнг хүлээн авах, ашиглах, судлаачидтай хамтран ажиллаж үйлдвэрлэлийн үр ашгаа нэмэгдүүлэх чадамж сул зэрэгтэй холбоотой юм.

Иймд инновацийн сүлжээнд шинэ мэдлэг, технологи, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, оролцогч талуудын бүтээлч хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, оюуны бүтээлийн арилжааны маркетинг, менежментийн тогтолцоог шинэчлэх, эрх зүйн орчин боловсронгуй болгох зэрэг асуудал нь тус салбарын өнөөгийн хөгжлийн эрэлт хэрэгцээ болж байна.

Дээр дурдсан эрх зүйн болон төлөв байдал, эрэлт хэрэгцээний шаардлага нь энэхүү инновацийн хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болсон юм.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Хүнс, хөдөө аж ахуйн салбар /цаашид “салбар” гэх/-ын үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх, өрсөлдөх чадамжийг бүрдүүлэхүйц тулхтай хөгжлийг хангах инновацийн экосистемийг хөгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

2.2.1. Салбарын эдийн засгийн үр өгөөжийг эрс нэмэгдүүлэх өндөр технологийн судалгаа ба хөгжил, инновацийн үйл ажиллагааны суурь бүтцийг хөгжүүлэх;

2.2.2. Салбарт мэдлэгийн эдийн засаг, инноваци хөгжих эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх;

2.2.3. Арилжаалагдах чадамжтай шинэ мэдлэг, технологи, инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөхүйлэн дэмжих, урамшуулах шинэ арга хэрэгсэл, маркетингийг боловсронгуй болгох;

2.2.4. Инновацийн тогтолцоонд оролцогч талуудын харилцан үр ашигтай, бүтээлч хамтын ажиллагааг идэвхжүүлэх, ногоон, дэвшилтэт технологийг нутагшуулах, бойжуулах үйл ажиллагааг дэмжих;

2.2.5. Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн үр дүнг хэрэглээ болгох, хурдацтай тархаах зөвлөх, нэвтрүүлэх үйлчилгээг эрчимжүүлж шинэ шатанд гаргах, чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх.

Гурав. Салбарын инновацийн тэргүүлэх чиглэл

3.1. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын шинжлэх ухаан, технологи, инновацийн экосистемийн дэд бүтэц, хөгжил, хөхүйлэн дэмжих үйл ажиллагаа нь дараах тэргүүлэх чиглэлтэй байна:

3.1.1. Био, нанотехнологи, генийн инженерчлэл, геномын ба протемиксын судалгаа ба хөгжил;

3.1.2. Мал, амьтны нөхөн үржихүйн биотехнологи, үржил селекци, удам зүй, генетикийн материал үйлдвэрлэлийн судалгаа ба хөгжил;

3.1.3. Малын бэлчээрийн ургамал зүйн хөдлөл, тэжээллэг, арчилгаа, маллагааны технологийн судалгаа ба хөгжил;

3.1.4. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох технологи, био бордоо, сэргээгдэх эрчим хүчний дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, нутагшуулах судалгаа ба хөгжүүлэлт;

3.1.5. Мал, амьтны өвчнийг оношлох, өвчнөөс сэргийлэх, эмчлэх технологийн судалгаа ба хөгжил;

3.1.6. Мал эмнэлгийн биобүтээгдэхүүний технологи, үйлдвэрлэл, хөгжүүлэлт;

3.1.7. Байгаль экологи, хөрсний үржил шимд ээлтэй технологийн судалгаа ба хөгжил;

3.1.8. Бүс нутгийн хөрс, цаг уурын онцлогт тохирсон, эдийн засгийн үр ашигтай таримлын үр, сорт, таримлын сэлгээний судалгаа ба хөгжил;

3.1.9. Хог ургамал, ургамлын өвчин, хортон шавьж, мэрэгчтэй тэмцэх ургамал хамгааллын бүтээгдэхүүний технологи, үйлдвэрлэл, хөгжүүлэлт;

3.1.10. Үйлдвэрлэлийн зориулалттай ашигтай бичил биетний судалгаа, үйлдвэрлэлийн технологи ба хөгжүүлэлт;

3.1.11. Шим тэжээллэг, органик, зохицуулах үйлчилгээтэй хүнсний технологи, үйлдвэрлэлийн судалгаа ба хөгжүүлэлт;

3.1.12. Хүнс, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, технологийн судалгаа ба хөгжүүлэлт.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1.Салбарын эдийн засгийн үр өгөөжийг эрс нэмэгдүүлэх өндөр технологийн судалгаа ба хөгжил, инновацийн ажил, үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1.Монгол орны эдийн засгийн эрэлт, хэрэгцээнд тулгуурласан, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн биотехнологи, нано технологийг нутагшуулах, технологи дамжуулах, технологи бойжуулах дэд бүтэц, технологийн инкубатор, шинжлэх ухаан, технологийн парк, шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх;

4.1.2.Биотехнологийн инкубаторыг байгуулан, технологи дамжуулах тогтолцоог боловсронгуй болгох, салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа инноваци, технологи дамжуулах төвийн үйл ажиллагааг дэмжих, өргөжүүлэх;

4.1.3.Шинжлэх ухаан, технологид суурилсан бизнес инкубатор, кластерын тогтолцоог хөгжүүлэх;

4.1.4. Шинжлэх ухаан, технологи, цөм технологи, инновацийн төслийн үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлж бодит үр дүн, шинэ мэдлэг, сайн туршлагыг олон нийтэд мэдээлэх, хэрэглэгчдэд түгээн дэлгэрүүлэх нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээг эрчимжүүлэх, цар хүрээг тэлэх;

4.1.5.ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдэд технологийн шинэ мэдлэг, сайн туршлага, дэвшилт технологийг ашиглах бодит эрэлт, хэрэгцээг мэдрэх, тодорхойлох чадамж бүрдүүлэхэд чиглэгдсэн цогц арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх;

4.1.6.Шинжлэх ухаан-үйлдвэрлэл-маркетинг-бизнес нэгдэлийн хамтын ажиллагааг хангах, шинэ бүтээгдэхүүнийг сурталчлах загвар төв (шинжлэх ухаан, технологийн парк) байгуулах чиглэлээр холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран ажиллах;

4.1.7.Төв, орон нутгийн хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид судлаачдын хамтран байгуулах гарааны компанийн үйл ажиллагааг дэмжих,

4.1.8.Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны академи болон Хөдөө аж ахуйн их сургууль, салбарын эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, орон нутаг дахь салбар, төвүүдийн чадавхид тулгуурлан хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх, дамжуулах;

4.1.9.Эрчимжсэн мал аж ахуй, тогтвортой газар тариалангийн, экологийн цэвэр хүнсний гэх мэт өндөр технологийн, бүтээмж, үр ашиг өндөртэй үйлдвэрлэлийн загвар аж ахуй, шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн кластер байгуулах хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

4.1.10.Инновацийн тухай хуулийн хүрээнд салбарын инновацийн санг бүрдүүлж, инновацийн ажил, үйлчилгээг хөгжүүлэхэд ашиглах;

4.1.11.Судлаачдын шинжлэх ухааны нээлт, бүтээлүүдийг бүртгэж, сурталчилах, мэдээллийн сан, сүлжээ бий болгох, оюуны өмчийн патент, эрхийг олон улсын түвшинд баталгаажуулах, тэдгээрийг худалдан авах, бизнес болгон хөгжүүлэх, арилжаалах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх.

4.2.Салбарт мэдлэгийн эдийн засаг, инноваци хөгжих эрх зүйн зохицуулалтын таатай орчинг бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1.Оюуны бүтээлийн эрхийн хамгаалалт, баталгаажуулалт, арилжаалахтай холбоотой эрх зүйн орчныг шинэчлэх;

4.2.2. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө, үндэсний хөтөлбөрүүдэд мэдлэгийн эдийн засгийг хөгжүүлэх, инновацийг дэмжих зорилтуудыг тухай бүрт тусгаж хэрэгжүүлэх;

4.2.3.Салбарын инновацийн суурь бүтцийн хөгжил, үйлдвэрлэл, үйлчилгээний хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;

4.2.4. Судалгаа, хөгжүүлэлтийн ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, зуучлах, нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

4.2.5. Мэдлэгт суурилсан байгалийн болон биологийн нөөцөд ээлтэй, ногоон, ухаалаг эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэгдсэн Малын генетик нөөцийн тухай, Таримал ургамлын генетик нөөцийн тухай, Органик хүнсний тухай хуулийг боловсруулж хэлэлцүүлэн Биологийн олон янз байдлын олон улсын конвенцийн хэрэгжилтийг хангах;

4.2.7. Хүнс хөдөө аж ахуйн ургамлын олон улсын гэрээнд нэгдэх, таримлын нөөцийг үр ашигтай, зохистой ашиглах тогтолцоог бүрдүүлэх;

4.2.8. Хүнс, хөдөө аж ахуйн биотехнологи, биоаюулгүй байдал, ёс зүйн эрх зүйн орчинг бүрдүүлэх;

4.2.9. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд зохистой дадлыг нэвтрүүлэх хэвшүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

4.2.10. Инновацийн болон өндөр технологийн үйлдвэрлэл явуулах зориулалттай технологийн машин, багаж, тоног төхөөрөмжийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг чөлөөлөх эрх зүйн орчныг бүрдүүлэх.

4.3. Арилжаалагдах чадамжтай шинэ мэдлэг, технологийг бий болгох үйл явц, инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөхүйлэн дэмжих, урамшуулах шинэ арга хэрэгсэл, маркетингийг боловсронгуй болгох зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.3.1. Үйлдвэрлэлийн зориулалттай ашигтай бичил биетний судалгааг эрчимжүүлж, хэрэглээний үр дүнг нэмэгдүүлэх;

4.3.2. Даавар, фермент, пептид, уураг нийлэгжүүлэх судалгаа ба хөгжүүлэлтийн технологийн инкубаторыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

4.3.3. Шилжмэл гентэй эд, эс, мал, амьтан, ургамлын сорт, эм, биобэлдмэл, хүнс зэргийг гарган авах судалгаа ба хөгжүүлэлтийн технологи бойжуулалтыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

4.3.4. Бактери, вирусын рекомбинант омгийг олшруулан үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болгон ашиглах, нэвтрүүлэх технологи бойжуулалтыг дэмжих;

4.3.5. Монгол орны онцлогыг шингээсэн, экологийн цэвэр бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхийн тулд уламжлалт мэдлэг, инновацийг хослуулсан шинэ бүтээмжит технологийг бий болгох;

4.3.6. Ногоон, дэвшилтэт технологийг нутагшуулах, бойжуулахыг бодлогоор дэмжих;

4.3.7. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд технологийн шинэчлэл хийсэн, экологи, хүрээлэн буй орчинд ээлтэй ногоон технологи ашигласан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг урамшуулал, татварын уян хатан тогтолцоог бий болгох, үйлдвэрлэгчдийг дэмжих;

4.3.8. Хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн судалгаа, инновацийн бүтээгдэхүүнийг хөрөнгө оруулалтаар дэмжих;

4.3.9. Салбарын эрдэм шинжилгээ, дээд боловсролын байгууллагуудаас үйлдвэрлэгчдэд илүү нээлттэй байх, туршилт, судалгааны ажлыг хамтран гүйцэтгэх, үр дүнг хамтран ажиллах санал, санаачилгыг бодлогоор хөхүйлэн дэмжих;

4.3.10. Оюуны багтаамж өндөртэй, бизнесийн болон нийгмийн эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн бүх хэлбэрийн үйл ажиллагааг эдийн засгийн үр өгөөжөөс хамааруулан дэмжих;

4.3.11. Таримлын сортыг нутагшуулах, үрийн хэрэгцээг хангах, тариалан, үрийн аж ахуйн тогтолцоог сэргээн хөгжүүлэх судалгааг эрчимжүүлэх.

4.4. Инновацийн тогтолцоонд оролцогч талуудын харилцан үр ашигтай, бүтээлч хамтын ажиллагааг идэвхжүүлэх, ногоон, дэвшилтэт технологийг нутагшуулах, бойжуулах үйл ажиллагааг дэмжих зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.4.1.Шинжлэх ухаан, технологийн дэвшлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, судалгаа хөгжүүлэлтийн ажилд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, инновацийн үйл ажиллагааг идэвхижүүлэх;

4.4.2.Монгол мал, тэдгээртэй филогенез холбоо бүхий аргаль хонь, янгир ямаа, хавтгай тэмээ, хулан адуу, тахь адуу зэрэг амьтдын генетикийн судалгаа, монгол малын гарал үүслийг тогтоох, улмаар малын ашиг шимийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үржил селекцийн ажлын хөтөлбөрийг боловсруулахад холбогдох байгууллага, судлаачтай хамтран ажиллах;

4.4.3.Инновацийн ажил, үйлчилгээ эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүмүүс, шинэ түншлэлүүд, мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг хамтран ажиллах үйл ажиллагааг дэмжиж, инновацийн маркетингийн төлөвшүүлэх;

4.4.4.Инновацийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хүргэх, зуучлах үйлчилгээ, маркетинг идэвхижүүлэлтийн арга хэмжээг салбарын яамны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тухай бүр тусгаж, хэрэгжилтийг хангах;

4.4.5.Бизнес эрхлэгчдэд инновацийн ач холбогдлыг таниулах, анхлан туршигчдад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээгээр хангах.

4.5.Шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг хэрэглээ болгох, хурдацтай түгээх, нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээг эрчимжүүлэх, чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.5.1.Салбарын эдийн засгийн үр өгөөжийг эрс нэмэгдүүлэх боломж, технологийн сайжруулалт, төгөлдөршилтийг илрүүлэх, инновацийг идэвхижүүлэх;

4.5.2.Аж ахуйн нэгж, байгууллагын шинжлэх ухаан, техник, технологийн үйл ажиллагааны шинэчлэл, өндөр технологи ашиглалт, нэгжээс авах ашиг шимийн өсөлт, эрсдлийн бууралт, үр өгөөжийг харгалзан дэмжих;

4.5.3.Нэвтрүүлэх, зөвлөх, зуучлах үйлчилгээнд оролцогч талуудын бүтээлч хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлэх, тэдгээрийн чадамж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх;

4.5.4.Салбарын мэргэжилтнүүд, үйлдвэрлэл эрхлэгчдэд нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээ, инновацийн талаарх мэдлэг олгосон сургалт, идэвхижүүлэлтийг бий болгох, сургалт мэдээллийн нэгдсэн сан бий болгох.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, удирдлага, зохион байгуулалт

5.1.Хөтөлбөрийн 2016-2020 оны хугацаанд хэрэгжүүлнэ.

5.2.Хөтөлбөрийн үйл ажиллагааг салбарын инновацийн тогтолцоонд оролцогч талууд хамтран зохион байгуулна.

5.3.Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг 2 жил тутамд хийнэ.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт

6.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь хөрөнгийн эх үүсвэрийг ашиглана:

6.1.1.улсын болон орон нутгийн төсөв;

6.1.2.эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн дэргэдэх шинжлэх ухаан, технологийн сан, гарааны компанийн орлого;

6.1.3.аж ахуйн нэгж, байгууллага, үйлдвэрийн хөрөнгө оруулалт;

6.1.4.олон улсын байгууллага,гадаад орнын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

6.1.5.инновацийн үйл ажиллагааны тусгай сангийн орлого.

Зургаа. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

	Шалгуур үзүүлэлт
1.	Салбарын өндөр технологийн судалгаа ба инновацийн суурь бүтэц:
1.1.	Өндөр технологийн судалгааны тоо
1.2.	Шинээр ашиглалтанд орсон өндөр технологи бүхий үйлдвэрийн тоо
1.3.	Гарааны компанийн тоо
1.4.	Технологийн болон бизнесийн инкубатор, кластерын бүтцийн тооны өсөлт
1.5.	Инновацид чиглэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнгийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэлт
2.	Эрх зүйн орчны шинэчлэл:
2.1.	Нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль
2.2.	Шинээр бий болгосон эрх зүйн баримт бичиг
3.	Инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл:
3.1.	Шинэ мэдлэгийн бүтээлийн тоо
3.2.	Инновацийн бүтээгдэхүүний тоо
3.3.	Арилжаалагдах чадамжтай шинэ мэдлэг, технологийн эзлэх хувь
3.4.	Инновацийн грант, төсөл санхүүжилтийн өсөлт
4.	Дэвшилтэт технологийн нутагшуулалт, бойжуулалт:
4.1.	Салбарт шинээр нутагшуулсан дэвшилтэт технологийн тооны өсөлт
4.2.	Дэвшилтэт техник нэвтрүүлэлтийн хувь
4.3.	Шинээр нутагшуулсан малын үүлдрийн тоо
4.4.	Шинээр нутагшуулсан таримлын сортын тоо
4.5.	Дэвшилтэт технологи, техник нэвтрүүлсэн лабораторийн тоо
4.6.	Судалгааны ажлын шинэ онол арга зүйг эзэмшсэн судлаачдын тооны өсөлт
4.7.	Нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээ авагчдын тоо
5.	Судалгааны үр дүнг хэрэглээ болгох:
5.1.	Пробиотик, пребиотик бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлтийн хувь
5.2.	Төрөл бүрийн даавар, фермент, пептид, уураг нийлэгжүүлэх үйлдвэрлэл, технологийн судалгааны нэмэгдсэн хувь
5.3.	Хүнс, тэжээл, эмчилгээний ач холбогдолтой ургамлын шинэ сортын судалгааны тоо
5.4.	Гүн хөлдөөсөн үр, хөврөл үрийн дотоодын үйлдвэрлэлийн өсөлтийн хувь
5.5.	Нутгийн омог, өсгөвөр, биологийн материалыг ашиглан үйлдвэрлэсэн биобэлдмэл, вакцин үйлдвэрлэлийн өсөлтийн хувь
5.6.	Малын геномын судалгааны түвшин
5.7.	Вирусгүй төмсний үр үйлдвэрлэлийн эзлэх хувь

oo OO oo